

“ИНВЕСКОР АКТИВ ТЗК” ХХК  
#13 давхар, Твин тауэр-1, Сөүлийн гудамж 10/1  
2-р хороо, СБД, 14251 Улаанбаатар  
Утас: 99099593, 90060254

2021.01.07 № А-21/03

Г Үнэт цаасны анхдагч арилжааны Г  
хуваарилалтын төлөвлөгөө хүргүүлэх  
тухай

“Инвескор Актив ТЗК” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн Монголын Хөрөнгийн Бирж (цаашид “Бирж” гэх)-ээр дамжуулан нийтэд санал болгон гаргаж арилжаалах Инвескор Актив хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Биржийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 11-р сарын 12-ны өдрийн А/75 тоот тушаал, 2020 оны 12-р сарын 28-ны өдрийн А/90 тоот тушаалаар тус тус бүртгэсэн билээ.

Компани нь нийт 4,000,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий Инвескор Актив хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 2021 оны 01-р сарын 13-аас 14-ний өдрийг дуусах хүртэл өглөөний 10 цаг 00 минутаас 16 цаг 00 минутын хооронд Биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 10 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнийн аргаар явуулах хүсэлтэй байгаа бөгөөд үнэт цаасны анхдагч арилжааны хуваарилалтын төлөвлөгөөг дараах байдлаар хүргүүлж байгааг хүлээн авна уу. Үүнд:

1. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Б транчийн нийт 600,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 1,500 ширхэг үнэт цаасны 500 ширхэг үнэт цаасыг Андеррайтер “Инвескор Капитал ҮЦК” ХХК, 750 ширхэг үнэт цаасыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Инвескор ББСБ” ХК, 250 ширхэг үнэт цаасыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч “Микро Кредит ББСБ” ХХК тус тус худалдан авна.

2. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан А транчийн нийт 3,400,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 8,500 ширхэг үнэт цаасны 50 хувьтай тэнцэх 4,250 ширхэг буюу 1,700,000,000 төгрөгийн үнэт цаасыг Биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 3.4 дэх хэсэгт заасны дагуу стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилах бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдын жагсаалт, хөрөнгө оруулагч тус бүрд хуваарилагдах үнэт цаасны тоо ширхэг болон бусад шаардлагатай мэдээллийг анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс өмнө Биржид хүргүүлэх болно.

3. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан А транчийн нийт 3,400,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 8,500 ширхэг үнэт цаасны 50 хувьтай тэнцэх 4,250 ширхэг буюу 1,700,000,000 төгрөгийн үнэт цаасыг олон нийтэд нээлттэй /жигжиглэнгийн хөрөнгө оруулагчдад/ хуваарилна. Мөн олон нийтэд нээлттэй хуваарилах үнэт цаасны худалдан авах захиалга нь 10,000,000 төгрөг буюу 25 ширхэг болон түүнээс бага дүнтэй байх тохиолдолд бүрэн биелэх нөхцөлтэй байна. Олон нийтийн худалдан авах захиалгын тоо ширхэг нь 4,250 ширхгээс илүү гарсан тохиолдолд нэгж хөрөнгө оруулагчийн 25 ширхэг үнэт цааснаас давсан үнэт цаасны захиалгыг хувь тэнцүүлэх аргыг ашиглан жигжиглэнгийн хөрөнгө оруулагчдад үнэт цаасны хуваарилалт хийнэ.

Хүндэтгэсэн,

ТУЗ-ИЙН ГИШҮҮН



Б.ЭНХМАРАЛ